

Монгол Улсад Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль 2022 оны 5 сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлнэ.

Холбоо барих:

Майкл Ахэрн

Партнер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
michael.ahern@pwc.com

Чойжамцын Цэндмаа

Захирал
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
tsendmaa.choijamts@pwc.com

Рагчаахүүгийн Мөнхжаргал

Хуулийн үйлчилгээний Менежер
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
munkhjargal.ragchaakhuu@pwc.com

Батчулууны Амаржаргал

Ахлах хуульч
Татвар, Хуулийн зөвлөх үйлчилгээ
amarjargal.batchuluun@pwc.com

Өмгөөллийн

ПрайсуотэрхаусКүүпэрс Легал
ХХН

Сентрал Тауэр, 6 давхар
603 тоот, Улаанбаатар
14200, Монгол улс
Утас : + 976 70009089
Факс : +976 11 322068
www.pwc.com/mn

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын Их Хурал Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг ("ХХМХХ") баталсан бөгөөд тус хууль нь 2022 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлнэ. ХХМХХ хүчин төгөлдөр болмогц Монгол Улсын хувьд өмнөх хууль буюу Хувь хүний нууцын тухай хууль (1995)-тай харьцуулахад хүний хувийн мэдээлэлтэй холбоотой зохицуулалтууд нь илүү өргөн хүрээтэй бөгөөд илүү хатуу зохицуулалттай болохоор байгаа юм.

ХХМХХ нь Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021), Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (2021), Цахим гарын үсгийн тухай хууль (2021) (тус тус 2022 оны 5-р сарын 1-ээс эхлэн хэрэгжиж эхэлнэ)-тай харилцан уялдаатай үйлчлэх бөгөөд, Монгол Улсад кибер аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хамгаалах цогц тогтолцоог бүрдүүлэх зорилготой юм. Бид ХХМХХ-ийн гол онцлог зохицуулалтууд болон түүний бизнест үзүүлэх нөлөөллийг энэхүү мэдээллээрээ онцолж байна.



Хамрах хүрээ

ХХМХХ нь Монгол Улс дах хүний хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах, боловсруулах болон хамгаалах харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад (Төлөөлөгчийн газар, Төлөөний газар) хамаарна.



Шинээр орж ирсэн нэр томъёо, тодорхойлолт

1. Хүний хувийн мэдээлэл гэж юу вэ ?

- ☐ хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой мэдээллүүд. Үүнд:
 - хүний эмзэг мэдээлэл;
 - хүний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;
 - төрсөн он, сар, өдөр, төрсөн газар;
 - оршин суугаа газрын хаяг;
 - байршил;
 - иргэний бүртгэлийн дугаар;
 - хөрөнгө;
 - боловсрол;
 - гишүүнчлэл; болон
 - цахим тодорхойлогч.



2. Хүний эмзэг мэдээлэл гэж юу вэ ?



- ☐ хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллүүд.

3. Мэдээллийн эзэн гэж хэн бэ ?

- ☐ Дээр дурдагдсан мэдээллээр тодорхойлогдож байгаа хүн.

4. Мэдээлэл хариуцагч гэж хэн бэ ?

- ☐ Хуульд заасны дагуу, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлийн дагуу мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглаж байгаа хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага.



Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан "PwC" нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсуотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК болон ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-г илэрхийлнэ.




Шинээр орж ирсэн нэр томьёо, тодорхойлолт (үргэлжлэл)




Ашиглах

мэдээллийг цуглуулах, боловсруулахаас бусад хэлбэрээр үйл ажиллагаандаа хэрэглэх, дамжуулах болон мэдээлэлтэй танилцах.



Цуглуулах

мэдээллийг олж авах, бүрдүүлэх, бүртгэх үйл ажиллагаа



Боловсруулах

мэдээллийг ангилах, хадгалах, дүн шинжилгээ хийх, өөрчлөх, устгах, сэргээх үйл ажиллагаа, тэдгээрийн нийлбэр.



Хуулийн гол шаардлагууд

1. Хүний хувийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үндэслэл

Хувь хүний нууцын тухай хууль (1995) нь "хуулийн шаардлага"-аас бусад тохиолдолд хувийн мэдээллийг боловсруулахыг зөвшөөрөх эсэх талаар тодорхой зохицуулалтгүй бөгөөд "зөвшөөрөл" авах гэсэн шаардлагыг тодорхой тусгаагүй юм. ХХМХХ-ийн дагуу хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь дараах тохиолдолд хүний хувийн мэдээллийг цуглуулж, боловсруулж, ашиглах боломжтой гэж заасан. Эдгээр нь:

- мэдээллийн эзнээс зөвшөөрлөөр;
- хуульд заасан үндэслэлээр;
- хөдөлмөрийн харилцааны явцад мэдээлэл хариуцагч эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх;
- гэрээ байгуулах, байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангах;
- хуульд заасны дагуу нийтэд ил болгосон;
- хүнийг тодорхойлох боломжгүй болгож түүх, эрдэм шинжилгээ, урлаг, утга зохиолын бүтээл туурвих, нээлттэй өгөгдөл, статистикийн мэдээлэл бэлтгэх.

2. Мэдэгдэл болон зөвшөөрөл авахад тавигдах шаардлага

Хүний хувийн мэдээллийг цуглуулах, ашиглах болон боловсруулахад мэдээллийн эзнээс цаасаар эсхүл цахимаар зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Мэдээлэл хариуцагч мэдээллийн эзэнд дараах нөхцөлийг мэдэгдэж, зөвшөөрөл авна:

- үндэслэл, зорилго ойлгомжтой, тодорхой байх;
- мэдээлэл хариуцагчийн нэр, холбоо барих мэдээлэл;
- цуглуулах, боловсруулах, ашиглах мэдээллийн жагсаалт;
- мэдээлэл боловсруулах, ашиглах хугацаа;
- мэдээллийг нийтэд ил болгох, мэдээллийг бусдад дамжуулах эсэх, дамжуулах этгээд, болон дамжуулах мэдээллийн жагсаалт (дамжуулахаар бол) болон зөвшөөрлөө цуцлах хэлбэр.



3. Мэдээллийг гадаад улс дахь хүн, хуулийн этгээд болон олон улсын байгууллагад дамжуулах

Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд зааснаас бусад тохиолдолд, эсхүл мэдээллийн эзэн зөвшөөрөл өгснөөс бусад тохиолдолд мэдээллийг гадаад улс дахь хүн, хуулийн этгээд болон олон улсын байгууллагад дамжуулан өгөхийг хориглоно. Хуульд энэхүү зөвшөөрөл авах шаардлагад хамаарахгүй гэж тусгайлан тусгаагүй тул групп доторх шилжүүлэг (хүний хувийн мэдээллийг гадаад дахь нэг групп компаниас нөгөө компанид шилжүүлэх)-ийг хувийн мэдээллийг дамжуулах гэж үзэхээр байна.

4. Мэдээлэл боловсруулагч

ХХМХХ-ийн дагуу мэдээлэл хариуцагч мэдээлэл цуглуулах, боловсруулах үүргийг гэрээний үндсэн дээр мэдээлэл боловсруулагчид шилжүүлж болно.

5. Мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээ

ХХМХХ-иар мэдээлэл боловсруулагч болон мэдээлэл хариуцагч нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үнэлгээнүүд хийх шаардлагыг тусгасан. Ялангуяа, мэдээлэл хариуцагч хүний оролцоогүй цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах дараах тусгайлсан тохиолдлуудад мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээг хийлгэх ёстой. Энэ нь:

- мэдээллийн эзний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлөхүйц шийдвэр гаргадаг бол; эсхүл
- хүний эмзэг мэдээллийг байнга боловсруулдаг бол.

6. Хүний хувийн мэдээллийг устгах шаардлага

Мэдээллийн хариуцагч нь хувийн мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, боловсруулж, ашиглаагүй бол мэдээллийн эзний хүсэлтээр, эсхүл мэдээллийг устгахаар мэдээлэл хариуцагчид үүрэг хүлээлгэсэн бол, эсхүл гэрээнд заасан буюу харилцан тохиролцсон бол хувийн мэдээллийг устгах шаардлагатай. Мөн мэдээллийг анх цуглуулсан зорилгодоо хүрсэн бол мэдээлэл хариуцагч тухайн мэдээллийг устгахаар хуульчилсан байна.



Мэдээллийн эзний эрх

Мэдээллээ дамжуулах

Хувийн мэдээллээ мэдэх

Өөрт хамааралтай мэдээллийг цуглуулсан, боловсруулсан, ашигласан эсэхийг мэдэх

Мэдээллийг хууль тогтоомжийн дагуу цуглуулахыг хориглосон, устгахаар заасан бол хэрэгжүүлэхийг шаардах

Мэдээллийг устгуулах

Мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад цуцлах хүсэлт гаргах

Мэдээллээ залруулах

Өөрт хамааралтай мэдээллийн хуулбарыг мэдээлэл хариуцагчаас цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргуулан авах

Мэдээллийг боловсруулсны үр дүнд гарсан шийдвэрт гомдол, тайлбар гаргах



Мэдээлэл хариуцагчийн үүрэг

Хүний хувийн мэдээлэл хамгаалахтай холбоотой мэдээлэл хариуцагчийн гол үүргүүдийг онцоллоо. Эдгээр нь:

мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах **журам баталж, мөрдүүлэх**

мэдээллийн эзнийг таньж, баталгаажуулсны үндсэн дээр түүний талаар **мэдээлэл цуглуулах зөвшөөрөл** авах

мэдээллээр хангах, мэдээлэл цуглуулж байгаа **зорилго, үндэслэл, зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхийн** талаар ойлгомжтой, тодорхой тайлбарлах



мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны талаар **бүртгэл хөтлөх**

мэдээллийн эзний гомдлыг **хүлээн авч шийдвэрлэж, хариу мэдэгдэх**

Хуульд заасны дагуу **үнэлгээнүүдийг хийлгэх / хийх**

мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах талаар мэдээллийн эзэн, хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллага, гуравдагч этгээдийн өмнө **хариуцлага хүлээх**

мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийг **засах, өөрчлөх, устгах**, энэ талаар мэдээллийн эзэнд мэдэгдэх

мэдээллийн эзний хүсэлтийн дагуу мэдээллийн **хуулбарыг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй өгөх**

мэдээллийн эзний хүсэлтийг хүлээн авсны дараа бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхгүй бол мэдээлэл боловсруулах, ашиглах **үйл ажиллагааг цуцлах**

Хуульд заасны дагуу **мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ** авах





Мэдэгдэл, тайлагнах хуулийн шаардлага

Хүний Эрхийн Үндэсний Комисст тайлагнах хуулийн шаардлага (“ХЭҮК”)

- Мэдээлэл хариуцагч нь зөрчил, түүний сөрөг үр дагаврыг арилгах талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл хөтөлж, уг бүртгэлийг жил бүрийн Нэгдүгээр сард ХЭҮК-т хүргүүлнэ.
- Үнэлгээг Хүний эрхийн Үндэсний Комисст хүргүүлж, зөвлөмж гаргуулсны үндсэн дээр цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглана.



Хариуцлага

ХХМХХ-ийн хамт Зөрчлийн тухай хууль /2017 он/, Эрүүгийн хуульд /2015 он/ нэмэлт, өөрчлөлт оруулсан. Зөрчлийн тухай хуульд зааснаар хүний эмзэг мэдээллийг хууль бусаар олж авсан, боловсруулсан, шилжүүлсэн, задруулсан гэх зэргээр ХХМХХ-г зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ. Энэ тохиолдолд хуулийн этгээдийг 20.000.000 хүртэл төгрөгөөр торгох зохицуулалттай байна.

Түүнчлэн, мэдээллийн эзэн нь Хувийн мэдээллийг хамгаалах хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй гэж үзвэл ХЭҮК-д гомдол гаргаж болно. Мэдээллийн эзэн нь ХЭҮК-ын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол тухайн шийдвэрийг шүүхэд гомдол гаргаж болно.

Мөн, мэдээлэл хариуцагчийн хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг шаардах эрхтэй болно.



Цаашид авах арга хэмжээ

ХХМХХ-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллагууд нь дараах арга хэмжээг авч ажиллахыг зөвлөж байна. Эдгээр нь:

- Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас батлах үнэлгээ хийх журмын дагуу байгууллагын хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээг хийлгэх;
- ХХМХХ-ийн хэрэгжилтийг хангах үүднээс хуульд нийцэж байгаа эсэх дүн шинжилгээ хийх;
- Дараах асуудлуудыг хамарсан дотоод бодлого(ууд) ба/зааварчилгааг боловсруулах буюу шинэчлэх:
 - мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах;
 - мэдээллийн аюулгүй байдал;
 - мэдээллийг ашиглах, устгах; болон
 - мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгох.
- Хуульд заасан шаардлагад нийцсэн зөвшөөрлийн маягт, мэдээлэл цуглуулах нөхцөл, зөвшөөрөлтэй холбоотой мэдэгдэл болон аливаа шаардлагатай бусад маягтуудыг боловсруулж батлах;
- Үйлчлүүлэгчид, хамтрагч байгууллагууд болон гуравдагч талуудтай мэдээлэл боловсруулах гэрээ байгуулах/ шинэчлэх;
- Зөрчлийн талаар авсан хариу арга хэмжээний тухай бүртгэл бий болгох, бүртгэлийн хөтөлж;
- Мэдээлэл алдагдсан үед авах арга хэмжээ, мэдээллийн эзэн болон холбогдох төрийн байгууллагад мэдээлэл хүргэх төлөвлөгөөг хуульд нийцүүлэн батлах;
- Аудио, видео, дуу дүрс бичлэгийн төхөөрөмж ашиглахад хоригдох нөхцөлүүд болон бусад шаардлагуудыг анхаарах;
- Зөвшөөрөлтэй холбоотой мэдэгдлийг танилцуулж, мэдээллийн эзнээс зөвшөөрөл авах; болон
- 2022 оны 5-р сарын 1-ний өдрийн дотор хууль хэрэгжиж эхлэхээс өмнө цуглуулсан биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-ийг устгах.



Дээр дурдсан хуулийн гол шаардлагууд, хууль зөрчихтэй холбоотой эрсдэлүүд болон ХХМХХ-тай холбоотой аливаа бусад асуудлуудын талаар илүү дэлгэрэнгүй ярилцахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.

Дараах линкээр орж Хувийн мэдээлэл хамгаалах хуультай танилцана уу.

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390288615991>

pwc.com/mn

Энэхүү мэдээллийг Өмгөөллийн ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН-ээс бэлтгэсэн болно. Энэ мэдээлэлд багтсан материал нь зөвхөн ерөнхий мэдээллийн зорилготой бөгөөд энд тусгасан асуудал бүрээр олон талын, цогц шинжилсэн мэдээллийг агуулаагүй болно. Аливаа үйлдэл хийх (эс үйлдэх)-ээс өмнө үүнийг уншигч та өөрийн нөхцөл байдалд тохирсон тусгайлсан мэргэжлийн зөвлөгөө авах нь зүйтэй. Энэ мэдээллийн агуулгыг ашигласан үйлдэл, алдаа хийдлээс гарах аливаа хариуцлагыг бид хариуцахгүй болно.

© 2022 Бүх эрх нь хамгаалагдсан. Энэхүү танилцуулгад дурьдагдсан “PwC” нь PricewaterhouseCoopers International Limited (PwCIL)-ийн гишүүн байгууллага болох ПрайсуотэрхаусКүүпэрс Такс ТМЗ ХХК болон ПрайсуотэрхаусКүүпэрс Легал ХХН -г илэрхийлнэ.